



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг
чөлөөлж, томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам”, “Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөх гишүүд болон шинээр томилогдох гишүүдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Томилогдсон гишүүнд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журмыг мөрдөн ажиллахыг үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Н.Баярчимэг)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1116100944

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн
46 дугаар тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ
ГИШҮҮДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэрс	Чөлөөлөгдөх гишүүдийн нэрс	Томилогдох гишүүний нэр	Одоо эрхэлж буй албан тушаал
1	"Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК	Д.Амгалан (НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)	Д.Эрдэнэбаяр	Эдийн засгийн хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн газрын дарга
2		Б.Даваадалай (Сангийн сайдын зөвлөх)	Д.Отгонжаргал	Нийслэлийн Нийтийн тээврийн газрын дарга
3	"Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент" ХХК	Ж.Түвшинжаргал (хараат бус)		
4	"Улаанбаатар спорт менежмент" ХК	Ж.Сандагсүрэн (НИТХ-ын Төлөөлөгч)		
5		Л.Нарантуяа (гишүүн)		
6		Д.Мөнхтуяа (гишүүн)		